



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/58

Хөхбүрд

Цол олгох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Хөх бүрд нуурын тахилга, сум байгуулагдсаны 77 жилийн ойн баяр наадамд Цол олгох бөхийн барилдаанд уран мэх хүч чадлаа гайхуулан барилдаж 7 давж түрүүлсэн О.Шинэхүүд сумын Заан, 6 давж үзүүрлэсэн О.Эрдэнэхуягт сумын Харцага, Г.Мэндбаярт сумын Начин цол тус тус олгосугай.

2.Цолны үнэмлэх, дагалдах мөнгөн шагналыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Д.Эрдэнэбулган)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Бөхийн холбооны комиссын дарга (Ж.Амартүвшин)-д даалгасугай.

ДАРГА  Г.ОРХОНТУУЛ



642301113